

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ДУУТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/163/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 70432545 цахим хаяг: ErdenetsetsegD@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
АОУС	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
УСНББОУС	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
ТШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
БСУГ	<i>Боловсрол, Соёл, урлагийн газар</i>
НДШ	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>
ХАОАТ	<i>Хүн амын орлогын албан татвар</i>
ЗДТГ	<i>Засаг даргын тамгын газар</i>
СТСХ	<i>Санхүү, Төрийн сангийн хэлтэс</i>
БШУЯ	<i>Боловсрол шинжлэх ухааны яам</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4. Менежментийн захидал	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

94000 Цамбагараа баг, Жаргалант сум, Ховд
Утас: 975-70433061, Факс: 975-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

Аудит. сан. акт. № а 194
тандай _____ -ны № _____ -т

ДУУТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Х.МӨНХТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургалтын үнэлгээ, сургалтын орчин, сургуулийн өмнөх боловсрол олгох, сургалтын арга зүйн мэдээллийн бодит байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

921020327

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>20,695,786.00</u>	<u>22,986,881.00</u>
33	АВЛАГА	1,976,374.00	1,979,974.00
335	Бусад авлага	1,976,374.00	1,979,974.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,976,374.00	1,979,974.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,719,412.00	21,006,907.00
351	Түүхий эд материал	-	1,347,400.00
35130	Эм боох материал	-	1,347,400.00
354	Хангамжийн материал	18,719,412.00	19,659,507.00
35420	Аж ахуйн материал	10,737,418.00	10,674,718.00
35460	Хүнсний материал	5,203,994.00	8,984,789.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>391,700,315.54</u>	<u>378,323,903.14</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	391,700,315.54	378,323,903.14
392	Биет хөрөнгө	387,291,315.54	374,029,153.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	384,049,187.00	384,049,187.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,418,582.62)	(39,704,602.74)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,627,320.00	40,213,672.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,687,810.08)	(27,925,815.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,722,480.00	46,732,480.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,417,278.76)	(29,751,767.96)
39217	Ном	416,000.00	416,000.00
393	Биет бус хөрөнгө	4,409,000.00	4,294,749.92
39301	Програм хангамж	532,000.00	532,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(75,000.00)	(189,250.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,952,000.00	3,952,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>412,396,101.54</u>	<u>401,310,784.14</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	412,396,101.54	401,310,784.14
51	Засгийн газрын хувь оролцоо	412,396,101.54	401,310,784.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	792,728,729.00	792,728,729.00
51101	Өмч: - төрийн	792,728,729.00	792,728,729.00
512	Хуримтлагдсан үр дүн	(382,100,368.46)	(393,185,685.86)
51210	Өмнөх үеийн үр дүн	(382,100,368.46)	(382,100,368.46)
51220	Тайлант үеийн үр дүн		(11,085,317.40)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,767,741.00	1,767,741.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>412,396,101.54</u>	<u>401,310,784.14</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	257,273,504.00	238,119,852.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,898,404.00	8,596,352.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,587,104.00	8,596,352.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,587,104.00	8,596,352.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,587,104.00	8,596,352.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	205,375,100.00	229,523,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	187,063,800.00	216,289,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	187,063,800.00	216,289,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,311,300.00	13,234,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,311,300.00	13,234,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	221,033,126.56	249,205,169.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	221,033,126.56	249,205,169.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	221,033,126.56	237,479,869.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,648,338.00	165,881,782.00
210101	Үндсэн цалин	130,220,405.00	162,885,689.00
210102	Нэмэгдэл	2,427,933.00	2,996,093.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,861,739.00	20,232,413.00
210201	Тэтгэврийн даатгал	12,039,949.44	14,217,253.53
210202	Тэтгэмжийн даатгал	1,223,056.47	1,675,313.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	968,057.15	1,340,250.93
210204	Ажилгүйдлийн даатгал	239,152.38	280,194.10
210205	Эрүүл мэндийн даатгал	2,391,523.56	2,719,400.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,856,088.00	16,160,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,321,674.00	2,577,400.00
210302	Түлш, халаалт	16,362,184.00	13,183,300.00
210303	Цэвэр, бохир ус	172,230.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,255,300.00	1,787,100.00
210401	Бичиг хэрэг	210,000.00	821,000.00
210402	Тээвэр, шатахуун	670,100.00	476,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,700.00	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	289,900.00	33,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	411,000.00

2105	Нормативт зардал	29,232,146.00	9,321,510.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,900.00	298,500.00
210502	Хоол, хүнс	29,190,246.00	8,944,010.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	79,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,300.00	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	39,400.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,950,315.56	23,896,364.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	554,300.00	1,923,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,396,015.56	21,972,764.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	11,725,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	11,725,300.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,725,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	36,240,377.44	(11,085,317.40)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,000,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	34,240,377.44	(11,085,317.40)

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	205,375,100.00	229,523,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	205,375,100.00	229,523,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	187,063,800.00	216,289,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	187,063,800.00	216,289,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,311,300.00	13,234,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,311,300.00	13,234,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	205,375,100.00	229,523,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	205,375,100.00	229,523,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	205,375,100.00	217,798,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	137,357,600.00	165,958,219.00
210101	Үндсэн цалин	89,370,800.00	101,136,188.00
210102	Нэмэгдэл	29,547,400.00	53,206,031.00
210104	Урамшуулал	9,622,400.00	11,616,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,817,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,169,800.00	20,155,737.00
210201	Тэтгэврийн даатгал	11,675,300.00	15,072,637.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,373,600.00	1,270,700.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,098,800.00	1,016,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	275,000.00	254,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,747,100.00	2,541,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,235,900.00	10,441,906.00
210301	Гэрэл, цахилгаан	1,996,500.00	1,251,906.00
210302	Түлш, халаалт	12,839,400.00	8,860,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	637,800.00	805,700.00
210401	Бичиг хэрэг	78,100.00	78,100.00
210402	Тээвэр, шатахуун	308,600.00	476,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	64,200.00	64,200.00
210404	Ном, хэвлэл	44,600.00	44,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142,300.00	142,300.00
2105	Нормативт зардал	29,788,200.00	15,519,705.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,900.00	1,630,900.00
210502	Хоол, хүнс	29,350,100.00	12,822,105.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,200.00	1,066,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,685,400.00	2,140,794.00
210604	Урсгал засвар	2,685,400.00	2,140,794.00
2107	Томилолт, зочны зардал	80,900.00	-
210702	Дотоод албан томилолт	80,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	818,800.00	216,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,800.00	16,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,700.00	2,559,639.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	819,500.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	781,200.00	2,559,639.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	11,725,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	11,725,300.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,725,300.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	--

C01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	792,728,729.00	1,767,741.00	(398,029,445.90)	396,467,024.10
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	792,728,729.00	1,767,741.00	(398,029,445.90)	396,467,024.10
C07	Тайлант үеийн үр дүн			15,929,077.44	15,929,077.44
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	792,728,729.00	1,767,741.00	(382,100,368.46)	412,396,101.54
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	792,728,729.00	1,767,741.00	(382,100,368.46)	412,396,101.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	792,728,729.00	1,767,741.00	(382,100,368.46)	412,396,101.54
D08	Тайлант үеийн үр дүн			(11,085,317.40)	(11,085,317.40)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	792,728,729.00	1,767,741.00	(393,185,685.86)	401,310,784.14

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	229523500.00	217798200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	229523500.00	217798200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	229523500.00	217798200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169517500.00	165958219.00
210101	Үндсэн цалин	103629800.00	101136188.00
210102	Нэмэгдэл	54271700.00	53206031.00
210104	Урамшуулал	11616000.00	11616000.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23016700.00	20155737.00
210201	Тэтгэврийн даатгал	16290500.00	15072637.00
210202	Тэтгэмжийн даатгал	1681600.00	1270700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1345300.00	1016800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	336400.00	254000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3362900.00	2541600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11092700.00	10441906.00
210301	Гэрэл, цахилгаан	1447400.00	1251906.00
210302	Түлш, халаалт	9245300.00	8860000.00
210303	Цэвэр, бохир ус	400000.00	330000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	805800.00	805700.00
210401	Бичиг хэрэг	78100.00	78100.00
210402	Тээвэр, шатахуун	476600.00	476600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	64,200.00	64,200.00
210404	Ном, хэвлэл	44,600.00	44,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142,300.00	142,300.00
2105	Нормативт зардал	19,607,700.00	15,519,705.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,630,900.00	1,630,900.00
210502	Хоол, хүнс	16,910,100.00	12,822,105.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,066,700.00	1,066,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,141,800.00	2,140,794.00

210604	Урсгал засвар	2,141,800.00	2,140,794.00
2107	Томилолт, зочны зардал	80,900.00	-
210702	Дотоод албан томилолт	80,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343,600.00	216,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	16,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,916,800.00	2,559,639.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,916,800.00	2,559,639.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	229,523,500.00	217,798,200.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	216,289,000.00	205,215,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	216,289,000.00	205,215,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,234,500.00	12,582,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	13,234,500.00	12,582,700.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14.00	14.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1.00	1.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1.00	1.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1.00	1.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	14.00	14.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00
650010	Гэрээт ажилтан	2.00	2.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Нэмэлт санхүүжилтээр орлого оруулж зарцуулаагүй.

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Х.Мөнхтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл,

анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалт, шилэн данс, үндсэн хөрөнгийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж, хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшилд анхаарч, хамран сургах тойргийн 2-5 насны хүүхдүүдэд үндсэн болон хувилбарт хэлбэрээр сургалт явуулж сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын амжилт чанарыг сайжруулах, багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажиллажээ. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ Эх хэлний чадварыг хөгжүүлэх
- ✓ Боловсролын үйлчилгээнд хүн бүр оролцогч байх чадамжийг дээшлүүлэх
- ✓ Суралцах чадвар, сургалтын чанарт ахиц гаргах
- ✓ Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэх
- ✓ Сумын 2-5 насны бүх хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургах ажлыг үр дүнтэй зохион байгуулан, сургуулийн өмнөх боловсролд 5-н настай хүүхдийг бүрэн хамруулж, цэцэрлэгийн хамран сургалтыг 0,3 хувиар ахиулах
- ✓ Үндсэн болон хувилбарт, явуулын чиглэлээр үйлчилгээг хүргэж хамтарч ажиллах
- ✓ Цэцэрлэгийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог өргөжүүлж, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг сайжруулах, хүүхэд хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлж нийгмийн эгэх хариуцлагыг нэвтрүүлж сайжруулах
- ✓ Монгол улсын засгийн газраас баталж гаргасан тогтоол шийдвэр, аймаг, суманд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, үр дүнг нээлттэй болгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг БШУЯ-наас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор БСУГ-ын дотоод хяналтыг 2020 онд тус байгууллагад хэрэгжүүлээгүй ч аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт хийж 2.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож бүрэн барагдуулсан байна. Мөн сумын Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 223230.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2230.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 401310.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4013.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11085.3 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	1,976.3	1,979.9	3.6
БАРАА МАТЕРИАЛ	18,719.6	21,006.9	2,287.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	391,700.2	378,324.0	-13,376.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	412,396.1	401,310.8	-11,085.3
БОГИНО ХУГАЦААТ ӨР	0.0	0.0	0.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН	412,396.1	401,310.8	-11,085.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР	412,396.1	401,310.8	-11,085.3

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 3.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд үүссэн авлагыг бүрэн барагдуулж ажилласан байна. Хүн амын орлогын албан татвар илүү шилжүүлээд авлага тусгаагүй байна. Аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг барагдуулсан байна.

Тайлант онд хувь хүн, аж ахуйн нэгжтэй холбоотой тооцоо хийсэн боловч тооцооны үлдэгдлийн актаар баталгаажуулаагүй насжилт өндөртэй авлага барагдуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 21006.9 мянган төгрөг болж 2287.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хүүхдийн хоолны мах нөөцөлж бараа материалд үлдэгдэлтэй харагдаж байгаа нь нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 391700.2 мянган төгрөг, оны эцэст 378324.0 мянган төгрөг болж 13376.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд төсвийн хөрөнгөөр хөрөнгө худалдаж аваагүй БСУГ-аас үнэ төлбөргүй хөрөнгөөр 8596.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж орлого авч элэгдлийн зардал 4779.9 мянган төгрөгөөр өссөн, хөрөнгө акталж зарлагдаагүй байна.

Өр төлбөр оны эхэнд үлдэгдэл байхгүй тайлант онд 217047.2 мянган төгрөгийн өр үүсэж бүрэн барагдуулсан бөгөөд тайлант оны эцэст өрийн үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 401310.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эхнээс 11085.3 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр буурсан байна.

Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 19153.7 мянган төгрөгөөр буюу 23.2 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 19153.7 мянган төгрөгийн орлого хүүхдийн хоолны хэмнэлт болох 19153.7 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 28132.1 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 28132.1 мянган төгрөгийн зардал нь цалингийн зардал 28132.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бодлогын өөрчлөлтөөр бүртгэлийн бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 232560.4 мянган төгрөгөөр нийт зарлагыг 232560.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд тусгай зориулалтын шилжүүлгээс 216289.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 13234.5 мянган төгрөгөөр нийт үйл ажиллагааны зардлыг 229523.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 229523.5 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 216289.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 13234.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 229523.5 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 216289.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 13234.5 мянган төгрөгийн санхүүжилт авч 217798.2 мянган төгрөг зарцуулж 11725.2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарган төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 217798.2 мянган төгрөг буюу 92% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрөөс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,702.9
80109	Тогтмол зардал	651.8
81806	Хоол хүнс	5,773.9
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	3,596.6
ДҮН		11,725.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар орлого бүрдүүлээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 143 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 143, мэдээллийг огт оруулаагүй 1, мэдээлэл дутуу оруулсан 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулснаас зарлагын 1 мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Дуут сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах албан шаардлага, зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага					-	-	-
Зөвлөмж	2	9,817.5	2	9,817.5	-	-	100
Нийт дүн	2	9,817.5	2	9,817.5	-	-	100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 5338.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1474.6 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3864.2 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа: Аудитаар тайлант хугацааны санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар төлбөрийн 1474.6 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож албан шаардлага өгдсөнгүй.

1. Цалингийн зардал

- 1.1. Илрүүлэлт: Цалингийн суутгалаас суутгасан ашиг илүү төвлөрүүлээд авлагаар тусгаагүй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй 337.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, төсөв хэтрүүлэн зарцуулсан байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төлбөрийн акт тогтоох
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Бараа материал

- 2.1. Илрүүлэлт: Хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлыг төвлөрүүлээгүй урсгал засварын зардалд зориулалт бусаар зарцуулсан 1137.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
- 2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, төсөв зориулалт бусаар зарцуулсан байх
- 2.3. Өгсөн зөвлөмж: Төлбөрийн акт тогтоох
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Аудитын зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 3864.2 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар үр дүнгийн урамшууллын тушаал шийдвэрийн хэрэгжилт, махны нөөцийн үлдэгдлийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3. Бараа материал

- 3.1. Илрүүлэлт: Бараа материалын зардал шилжүүлэхдээ е-баримтгүй гүйлгээ хийсэн, өглөг авлага тооцоогүй шууд зардлаар бүртгэсэн 1580.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
- 3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх

3.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж е-баримтын хэрэгжилтийг хангаж ажиллах,

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Авлага

4.1. Илрүүлэлт: Насжилт өндөртэй авлага бууруулаагүй, эзэн холбогдогчтой нь тооцоо нийлж баталгаажуулаагүй 1976.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

4.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал хангагдахгүй байх, төсөв үргүй зарцуулагдах

4.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэсэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

5. Хөрөнгө, материал

5.1. Илрүүлэлт: Хүнсний бүтээгдэхүүн болон махны гарал үүслийн бичиггүй, хүүхдийн хоолны талон засварласан, хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, нярвын тайлан эмх цэгцгүй, дотоод хяналт сул байгаа 307.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

5.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал хангагдахгүй байх, хөрөнгийн ашиглалт буурах

5.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэсэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/163/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Дуут сумын Цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлыг төвлөрүүлээгүй урсгал засварын зардалд зориулалт бусаар зарцуулсан	1137.3	Төлбөрийн акт	Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Х.Мөнхтуяа, Л.Цэвэлмаа
2	Цалингийн суутгалаас суутгасан ашиг илүү төвлөрүүлээд авлагаар тусгаагүй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй	337.3	Төлбөрийн акт		
3	Бараа материалын зардал шилжүүлэхдээ е-баримтгүй гүйлгээ хийсэн, өглөг авлага тооцоогүй шууд зардлаар бүртгэсэн,	1580.0	Зөвлөмж		
4	Насжилт өндөртэй авлага бууруулаагүй, эзэн холбогдогчтой нь тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1976.4	Зөвлөмж		
5	Хүнсний бүтээгдэхүүн болон махны гарал үүслийн бичиггүй, хүүхдийн хоолны талон засварласан, хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, нярвын тайлан эмх цэгцгүй, дотоод хяналт сул байна	307.8	Зөвлөмж		
ДҮН		5338.8			

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР